



МОНГОЛ АЛТ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 сарын 28-ны өдөр

№ 01

Дархан хот

Хувьцаа эзэмшигчдийн хурал 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт Монгол-Алт ХК-ийн офисын хурлын танхимд эхлэв.

Хурлын ирц:

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн бүртгэлд хувьцаа эзэмшигч М.Цолмон, Л.Амарсанаа, Б.Саруул, М.Оюун, М.Жавхлан, Ж.Мөнхтөр, Ж.Мягмаа, Б.Батром, А.Болор-Эрдэнэ, Л.Базарсад, А.Молор-Эрдэнэ нар бүртгүүлэн хуралд оролцов.

Л.Амарсанаа: - Нарийн бичгийн дарга С.Бат-Эрдэнэ ирцийг танилцуулна уу.

С.Бат-Эрдэнэ: - Компанийн нийт энгийн 265852 ширхэг хувьцаанаас 236036 ширхэг энгийн хувьцааг эзэмшигчид буюу 88,8 хувийн ирцтэйгээр хурал эхлэв.

Л.Амарсанаа: - Энэ удаагийн хурлыг даргалах хүнийг сонгон томилох юм байна.

Одоо “Монгол Алт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Амарсанааг хурлын даргаар сонгох саналтай хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү.

Ээлжит хуралдаанд оролцож байгаа хувьцаа эзэмшигчид бүрэн зөвшөөрлөө. Татгалзсан, түдгэлзсэн хүн байхгүй байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар хувьцаа эзэмшигч Л.Амарсанааг Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар томилсныг нийт хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид 100 хувь санал нэгтгэйгээр зөвшөөрөв.

Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, дотоод журмыг танилцуулъя. Өнөөдөр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 3 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэнэ,

Хоёрдугаарт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны зардлын төсөв, ТУЗ-ийн дарга, гишүүдийн урамшууллын хэмжээг батлах,

Гуравдугаарт, Ногдол ашиг хуваарилах тухай, бусад асуудлын тухай.

Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлахыг зөвшөөрч байгаа хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү.

Хуралдаанд оролцож байгаа хувьцаа эзэмшигчид бүрэн зөвшөөрлөө.

(Хурлын дарга Л.Амарсанаа хурлын дотоод журмыг танилцуулав).

Саналтай Хувьцаа эзэмшигч байна уу?

Хурлын дотоод журмд саналтай хүн байна уу? Байхгүй.

Хурлын дотоод журмыг баталъя гэж байгаа Хувьцаа эзэмшигчид гараа өргөн үү. Санал нэгтгэйгээр дэмжиж байна.

ХЭЛЭЛЦСЭН нь: - Эхний асуудлаа хэлэлцье. Компанийн 2024 оны санхүүгийн тайланг сонсож хэлэлцэнэ. Ерөнхий нягтлан бодогч Ж.Мягмаа танилцуулна.

Ж.Мягмаа: - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанд хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

“Монгол-Алт” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг танилцуулъя. Компанийн орлого энэ жил түрээсийн орлого, улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бүрдэж байгаа. Хоёр барилгын төслийн санхүүгийн байдлыг тусд нь танилцуулна.

Улсын төсвийн санхүүжилтийн орлого 1 тэрбум 260.9 сая төгрөг орсон, түрээсийн орлого 417.9 сая төгрөг, нийтдээ 2024 оны борлуултын орлого 1.6 тэрбум төгрөг болсон. Өмнөх жилээс 13.4 хувиар өссөн. Улсын төсвийн санхүүжилтийн орлого яагаад 2024 онд өмнөх жилээс өссөн шалтгаан нь өмнөх тендерүүд хаагдсантай холбоотой.

Санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй задаргааг уншиж танилцуулав (Дэлгэрэнгүйг Хурлын материалд хавсаргав).

Л.Амарсанаа:- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн О.Лувсаншарав санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг уншиж танилцуулна.

О.Лувсаншарав:- Санхүүгийн тайланг сонслоо. Хараат бус гишүүдийн дүгнэлтийг уншиж танилцуулъя.

Санхүүгийн тайланд хийсэн хараат бус гишүүдийн дүгнэлтийг уншиж танилцуулав. (Дэлгэрэнгүйг Хурлын материалд хавсаргав).

Л.Амарсанаа:- Баярлалаа. Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн урамшууллын хэмжээнд өөрчлөлт оруулъя гэсэн санал байгаа юм. Гүйцэтгэх захирал М.Цолмон танилцуулна.

М.Цолмон:- Компанийн ашигт үйл ажиллагаа, санхүүгийн төлөв нилээн өөдрөг байгаа. Барилгын салбарт үйл ажиллагаа эхлүүлсэн нь оночтой шийдэл болсон гэж үзэж байгаа. Барилгын ажлууд ид үргэлжилж байна. Иймд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын урамшууллыг нэмэгдүүлье гэсэн саналтай байна.

Л.Амарсанаа:- Гурван асуудлаа танилцууллаа. Танилцуулсан тайлан, Хувьцаа эзэмшигчдийг төлөөлж ажиллах Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн урамшууллыг нэмье гэсэн асуудалтай холбогдуулан асуулт явуулъя. Хувьцаа эзэмшигчид танилцуулсан асуудлуудтай холбогдуулан асуулт байвал асуугаарай.

О.Лувсаншарав:- Хараат бус дүгнэлттэй холбоотой асуулт асууж болно. 12 орчим төгрөгийн бүртгэл яваад байна. Яваандаа энэ маань эрэлтэндээ орно гэж ойлгоорой.

Ж.Мягмаа: - Барилгатай холбоотой Голден төслөө хаагаагүй байгаа. E-barimt бичихтэй холбоотой хаагдаагүй байгаа. НӨАТ энэ ондоо хаагдах гээд байгаа юм. 2025 онд цэгцэрнэ. Барилгын санхүүжилт ийм онцлогтой юм байна.

Л.Амарсанаа:- Нэмэлт асуулт байна уу?

Б.Батром:- Яагаад “Момо агро” компани яагаад ашиггүй байна? Ашиггүй салбарыг авч шаардлага байна уу?

Ж.Мягмаа:- Сүүлийн 3 жил алдсан. Яах аргагүй гурилын үйлдвэрүүдэд баригдаад байна. Үнийн асуудал маш чухал байгаа. Үнээр нь борлуулж чадахгүй байгаа. Энэ жил гуйж байж “Алтан тариа”-д зарсан. Хөдөө аж ахуйн корпораци арай өндөр үнээр авсан. Өртэй компаниудаасаа авсан юм.

М.Оюун:- Ер нь “Момо агро” компанийг дараа жилээс энэ байлгахгүй байх саналтай байна. Том компанийн нөмөр нөөлгөнд зардлаа шийдүүлж яваад байгаль, цаг уурын нөхцөл байдлаас гэдэг шалтгаан хэлдэг. Энэ байдлаар явж болохгүй. Хувьцаа эзэмшигчдийн хуралд энэ саналаа хэлье гэж бодож байна.

Б.Батром:- Миний бодлоор барилгын салбартаа илүү түлхүү ажиллах хэрэгтэй юм байна. Хүмүүс барилгын квадрат метрээс айхаа больсон байна. Барилгын явцыг эхлэхээс нь эхлээд үзэж, харж, хэр зэрэг ажил явагдаж байгаа ажигладаг, байнгын хяналтад байдаг юм байна.

Геолог бол боловсон хүчний дутагдалд орсон. Геологийн ангид жилд 5 хүүхэд төгсдөг болсон байна. Нэр хүнд унасан байна. Цаашид улсын ажил авбал тэр л биз. Зураглалын ажил маш хүнд ажил. Залуус цалин хөөж өөр ажилд шилжиж байна. Ажлын үнэлгээ багатай учраас ийм явдал болж байна.

Зураглалын ажил өндөр шалгууртай болсон байна. Миний хувьд бол нэр байна.

А.Болор-Эрдэнэ: - Надад нэг санал байна. “Момо агро” компани дээр мэргэжлийн агрономич хэрэгтэй байгаа гэж бодож байна. Мэргэжлийн хүн байж байж хөрсний шинжилгээ хийж байж үр өгөөж нэмэгдэх ёстой. Мэргэжлийн лабораторт шинжлүүлж үр өгөөжөө тооцох ёстой гэж бодож байна.

“Дулаан апартамент” дээр ашгийн талаар дотруулах зүйл байна. Одоо 9,6 тэрбум орчихсон байна. Одоо дахиад 6 орчим тэрбум төгрөг хэрэгтэй гэж байна. Одоо хүлээгдэж байгаа орлого хэд байгаа вэ?

Ж.Мягмаа:- 13.1 тэрбум төгрөг орж ирнэ.

М.Цолмон: - Энэ дээр буруу хэлсэн байна. 7.6 тэрбум төгрөг зардал гарсан байна. Ашиг нь 16 орчим тэрбум төгрөгийн ашигтай гарна.

М.Оюун:- Төсөвт өртгийн тооцоо норм, стандартын дагуу хийгдэхээр өндөр болоод байдаг.

Л.Амарсанаа:- Ж.Мягмаагаас асуух асуулт байна. Чи олон жил “Монгол Алт” компанийн санхүүг хариуцаж ажиллаж байна. Санхүүгийн сахилга бат ямар байна гэж үзэж байна. Аудитын шалгалт хэр тогтмол орж байна?

Ж.Мягмаа:- Жил бүр аудит орж байгаа. Аймгаас аудит ордог. Аудит хийх компаниуд 2 жил тутамд солигддог. Санхүүгийн хорооноос тийм шаардлага тавьдаг.

Л.Амарсанаа:- Тухайн байгууллагын санхүүг хариуцаж байгаа хүн сахилгатай байж хяналтын байгууллагатай харилцаж, Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журмыг ягштал мөрдөж, байгууллагуудтайгаа харилцаатай байж эрсдэлгүй гэсэн дүгнэлт гарна шүү дээ. Манай санхүүгийн үйл ажиллагааг яг юу гэж дүгнэж байна?

Ж.Мягмаа:- Татвар, нийгмийн даатгалынхан хяналтаа тогтмол тавиад явдаг.

М.Оюун:- Бүх юм онлайн болсон учраас Татварын алба дээр компаниудын тайланд “эрсдэлтэй”, “эрсдэлгүй” үнэлгээ гаргаад “эрсдэлтэй” гэсэн компаниудад шууд шалгалт оруулдаг болсон.

Л.Амарсанаа:- Манайд ажиллаж байгаа хүмүүсийн сахилгаас хамаарна. Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журмыг ягштал мөрдөж ажиллах чухал. Аудит болон бусад шалгалттай холбоотой ямар нэгэн шаардлага, зөрчил байгаа юу? Чи өөрөө дүгнэлтээ хэлчих.

Ж.Мягмаа:- Барилгатай холбоотой “Монголын Финтек групп”-ээс авсан долларын зээлээ хурдан хаах асуудал санаа зовоож байна. Энэ асуудлыг банкны зээл авч хаах шаардлагатай болно. Болж өгвөл банкны зээлд хүсэлтээ өгсөн боловч 2 сар өнгөрлөө. Долларын зээлээ хаах нь чухал байна.

Л.Амарсанаа:- Нийт хэдэн хүн чиний удирдлагад ажиллаж байна? Ажлын ачаалал жигд байна уу?

Ж.Мягмаа:- 22 хүн ажиллаж байгаа. Жигд, боломжын байгаа. Геологийн ажилд тендертэй холбоотой ажилд тусална.

Л.Амарсанаа:- Асуулт асууж дууслаа. Асуултаа тасалъя гэж байгаа Хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү. Тасаллаа.

М.Оюун:- Барилгын бизнесээр олон жил үргэлжлэхэд барилгын төсөл хэрэгжүүлэх газрын асуудал их чухал юм байна.

Л.Амарсанаа:- Өөр санал байна уу?

М.Цолмон:- Газар тариалангийн салбараас гарчихъя гэсэн бодолтой байгаа.

Л.Амарсанаа:- “Монгол Алт” компанийн үйл ажиллагаа 2024 онд барилгын чиглэлээр ажиллаж эхэлснээс хойш эргэлтийн жил болно гэж харж байсан. 2025 онд үйл ажиллагаа нь жигдрээд явна гэж дүгнэж байгаа.

Хоёрдугаарт, Цолмон байнга надтай цаашдын үйл ажиллагааныхаа талаар ярьж зөвлөдөг. Ерөнхийдөө одоо байгаа түвшингөө улам сайжруулж, цаашдаа санхүүгийн болон үйл ажиллагааны хувьд тогтвортой, тогтсон, найдвартай үйл ажиллагаатай компани болно гэсэн зорилготой тавьж байгаа.

Барилгын тухай “Голден таун” хотхоны 2, 3 дугаар блокийг бариад явж байна.

“Голден таун” явж байна. Дархан-Уул аймгийн ЗДТГ-аас зарласан дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгчээр шалгараад явж байгаа. Засаг дарга баталгаажуулвал цаашид энэ төслийг хэрэгжүүлээд явах юм. Хоёр айлын газрын асуудлыг шийдвэрлэгдвэл төсөл хэрэгжээд явна.

Зах зээлийн үйл ажиллагаа явуулчих боломж гарвал хөөцөлдөж ажиллана.

“Монгол Алт” компани санхүү, эдийн засгийн хувьд тогтворжиж байна. Энэ санаачилгыг гаргаж ажилласан хүн бол Гүйцэтгэх захирал М.Цолмон. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс сайшааж байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн урамшуулалд өөрчлөлт оруулъя гэсэн санал байна. Төлөөлөн Удирдар Зөвлөлийн даргын урамшуулал 200 мянган төгрөг, гишүүдийнх 180 мянган төгрөг, Нарийн бичгийн даргынх 120 мянган төгрөгөөр тогтоох саналтай байна.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11, 62 дугаар зүйлийн 62.1.9, “Монгол алт” ХК-ийн дүрмийн 8.4.9 дэх заалт, Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын 01 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Монгол алт” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн тайланг баталсугай.

2.Тус компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд, Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д тус тус үүрэг болгосугай” гэсэн тогтоол байна.

Тогтоол дээр асуулт байна уу? Байгүй.

Санал байна уу? Байхгүй.

Татгалзсан, түдгэлзсэн хүн байна уу? Байхгүй.

Тогтоол батлагдлаа.

Хоёрдугаарт, Ногдол ашиг хуваарилах тухай.

“Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8, 46.10 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.2.7 дахь заалт, “Монгол Алт” ХК-ийн дүрмийн 22.1 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дугаар сарын 28-ны өдрийн хурлын Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар нэгж хувьцаанд 370 (гурван зуун дал) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар тогтсугай.

2. Ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар зуучлуулан 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор тараалгахыг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д даалгасугай” гэсэн ийм тогтоол байна.

Тогтоол дээр асуулт байна уу? Байгүй.

Санал байна уу? Байхгүй.

Тогтоолыг баталъя гэсэн Хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү. Баталлаа.

Гуравдугаарт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны зардлын төсөв, дарга, гишүүдийн урамшууллын хэмжээг тогтоох тухай.

“Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, “Монгол алт” ХК-ийн дүрмийн 8.7 дахь хэсэг, Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хэвийн үйл ажиллагаа хангах 2025 оны зардлын төсвийг 21,120,000 (хорин нэгэн сая нэг зуун хорин мянга) төгрөгөөр тогтоосугай.

2. “Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, гишүүдийн урамшууллын хэмжээг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д үүрэг болгосугай” гэсэн тогтоол байна.

Тогтоолоос асуух асуулттай хүн байна уу? Алга.

Тогтоолыг баталъя гэсэн Хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү. Баталлаа.

Тооллогын комиссыг ажилд нь оруулъя.

Өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай явагдаж дууслаа. Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирж оролцсон та бүхэнд баярлалаа.

Цаашдаа бүгдээрээ компанийнхаа үйл ажиллагааг сайжруулахын төлөө хамтран зүтгэх болно.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

ХЯНАСАН



ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга
С.Бат-Эрдэнэ

ХУРЛЫН ДАРГА Л.АМАРСАНАА